

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 01 дүгээр сарын 26

Замын-Үүд сум

Тус газар нь Монгол улс, Олон улсын хэлэлцээр, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Боомтын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145, 339, 146 дугаар тогтоол журам тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, албан даалгаврыг тус тус удирдлага болгон гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилэхэд анхаарч 2018 оны 12 дугаар сарын 11-ны өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1 Монгол Улсын виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз олгохыг хүссэн 5 орны 44 иргэнд зохих зориулалт ангиллын визийг олгож, визийн хураамж болох 3,204,000.00 төгрөг, визийн үнэ болох 302,200.00 төгрөгийг Төрийн сангийн зохих дансанд нь төвлөрүүлэн ажилласан. Үүнд:

- Нэг удаагийн орох – 6 иргэн
- Олон удаагийн орох – 1 иргэн
- Нэг удаагийн гарах-орох – 33 иргэн
- Хоёр удаагийн удаагийн гарах-орох – 1 иргэн
- Визийн шилжүүлэг – 3 иргэн

1.2 Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэдийн талаар:

Боомт, орон нутгийн хэлтсийн даргын 2017.05.26-ны өдрийн 11/2092 тоотыг үндэслэн хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 754 иргэн /давхардсан тоогоор/-ний хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

1.3. Алдаатай визийн талаар:

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаас алдаатай олгогдсон БНХАУ-ын 7 иргэний визийг илрүүлэн, холбогдох арга хэмжээг авч визийн засвар хийн хилээр нэвтрүүлсэн.

1.4 Түр ирэгч бүртгэлийн талаар:

Украин улсын 2, БНХАУ-ын 20 иргэн нийт 22 иргэнийг бүртгэн, бүртгэлийн хураамж болох 44000 төгрөгийг зохих дансанд төвлөрүүлсэн.

1.5. Хасалт хийсэн талаар:

Украин улсын 2 иргэн, БНХАУ-ын 3 иргэн, Зөрчил гарган, захиргааны шийтгэл ногдуулан БНХАУ-ын 30 иргэн, Оршин суух зөвшөөрөлд уригчийн хүсэлтээр, ОСЗ хураалгасан БНХАУ-ын 61 иргэн нийт 96 иргэнд хасалт хийж Монгол Улсаас гаргасан ба ISM сүлжээнд хяналт тавих явцад илэрсэн АНУ-ын 1 иргэний ОСЗ-ын хугацаа дууссан учир нөхөн хасалт хийсэн болно.

1.6. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6-ийн дагуу Монгол улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй 1 орны 17 иргэнийг улсын хилээр оруулалгүй буцаан ажилласан.

1.7. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 1 орны 21 иргэнийг 2,890,000.00 төгрөг, 12 аж ахуйн нэгж байгууллагын 24 иргэнд 2,470,000.00 төгрөг, уригч 1 иргэнийг 10000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Дорноговь аймгийн Цагдаагийн газрын мэдээллийн дагуу Сайншанд суманд WSGI ХХК-ны үйл ажиллагааны бэлтгэл хангах зорилгоор зорчиж буй БНХАУ-ын 16 иргэний бичиг баримтанд шалгалт хийхэд илэрсэн зөрчил дутагдал гараагүй.

Говьсүмбэр аймаг дахь мэргэжилтэн, Говьсүмбэр аймгийн Тагнуулын тасгийн ажилтантай хамтран 2019 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын хоёрдугаар багийн нутаг дэвсгэр 21-р зөрлөгт “Нүүрс угаан боловсруулах үйлдвэр” болох БНХАУ-ын “Шаньдун Шенхан Жегэ эдийн засгийн худалдаа” ХХК-тай хамтарсан хөрөнгө оруулалттай “Страто” ХХК-нд ажиллаж байгаа гадаадын иргэдийн паспорт баримт бичиг шалгалт хийсэн. Шалгалтаар тус үйлдвэр дээр БНХАУ-ын 7 иргэн бичиг баримтын зөрчилтэй байсныг илүүлсэн. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 5 иргэнд зөрчлийн тухай хуулийн 16.2.3.3-д заасны дагуу 850,000.00 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, ГИЭЗБТх-ийн 37.1.7 дугаар зүйл болон Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журамны 3.7 дахь заалтад заасны дагуу Монгол Улсад 3 жилийн хугацаанд дахин нэвтрэх эрхгүйгээр албадан гаргасан. БНХАУ-ын 2 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2-3.3-д зааснаар торгуулийн арга хэмжээ авсан.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд Дорноговь аймаг дахь газрын дарга 8 тушаал батлан гаргасан ба үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээ, тус газрын үйл ажиллагааны тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар

Албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу “Хяналтын карт”, ирсэн бичиг, өргөдөл, гомдолд “Бүртгэл хяналтын карт”-ыг тухай бүр хөтөлдөг ба хариутай албан бичгийг стандартын дагуу боловсруулан ажилласан.

Тайлант хугацаанд 17 албан бичиг ирснийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 2 албан бичгийн хариуг өгч, 27 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Албан хаагчдаас чөлөө хүссэн 2 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн. Харин тус газарт ирсэн гомдол байхгүй болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтад 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр өөрчлөлт орсонтой холбогдуулан ГИХГ-ын даргын энэ оны Б/347 дугаар тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 28 бөгөөд бүртгэлтэй байгаа 25 албан хаагчаас 24 албан хаагч ажиллаж байна. Үүнээс хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч байна.

2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ТЕГ-ын Замын-Үүд дэх газраас “Төрийн болон албаны нууцын тухай хууль”-иар сургалт зохион байгуулж сургалтанд нийт 13 албан хаагч хамрагдаж сургалтаар төрийн болон албаны нууцын тухай ерөнхий ойголт,

төрийн албан хаагч гадаадад зорчиход анхаарх асуудлуудын талаар зохих мэдлэгийг олж авсан.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар

2019 оны 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр гарган Замын-Үүд сумын Төрийн сангийн мэргэжилтнээр хянуулан, Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлсэн.

2018 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган ndaatgal.mn цахим сайтад шивж, 20 албан хаагчийн нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийн, нийгмийн даатгалын тасгаар баталгаажуулсан.

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар:

- ✓ Тухай бүрт нь оруулах мэдээлэл-8
- ✓ Сар бүр оруулах мэдээлэл-3
- ✓ Улирал бүр оруулах мэдээлэл-1
- ✓ Хагас жил бүр оруулах мэдээлэл-1
- ✓ Жил бүр оруулах мэдээлэл-3 нийт 16 мэдээллийг хуулийн

хугацаанд шилэн дансны сайтад шивж байршуулсан. Мөн 12 дугаар сарын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн сарын тайланг 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Хяналт шинжилгээ, дотоод аудит орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.

Үнэт цаасны 12 дугаар сарын тайланг хяналтын улсын байцаагч нараас хүлээн авч хянан, 2019 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлсэн. 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар Төв газар болон Дорноговь аймаг дахь газраас Замын-Үүд сумын Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн орлого:

/төгрөгөөр/

Замын-Үүд сумын Төрийн сангийн данс	Гадаадын иргэн харьяатын газар	Дорноговь аймаг дахь газар	Нийт дүн
Хүү торгуулийн орлого	11,130,000.00	4,130,000.00	15,260,000.00
Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	97,710,660.00	2,640,000.00	100,350,660.00

Төв газрын дансанд 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар визийн хуудасны үнэ 229,200.00 төгрөгийг шилжүүлсэн байна.

2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд санхүүжилтийн 40,107,900.00 төгрөг, нийгмийн даатгалын сангаас 379,582.00 төгрөгийн орлогын гүйлгээ, зарлагын 71,781,070.02 төгрөгийн гүйлгээг Замын-Үүд төрийн сангаар хянуулан хийлгэж данс бүртгэлд бүртгэсэн. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил- 44,792,037.54 төгрөг
- Нийгмийн даатгалын шимтгэл- 12,963,642.70 төгрөг
- ХХОАТ-5,217,291.84 төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал- 9,920,611.00 төгрөг
- Тээвэр шатахууны зардал- 6,385,700.00 төгрөг
- Хангамж, бараа материалын зардал- 2,857,925.50 төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал- 308,000.00 төгрөг
- Томилолт, зочны зардал- 0.00 төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал- 49,900.00 төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал- 2,752,800.00 төгрөг
- Ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал- 1,996,799.60 төгрөг


- Нийгмийн даатгалын сангийн зарлага-379,582.00

2018 оны 12 дугаар сарын эцсийн цалин, 2019 оны 01 дүгээр сарын эцсийн цалинд 25 албан хаагчид цалинг бодож олгосон.

2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс 24-ний өдрийг хүртэлх хугацаанд Дорноговь аймгийн Төрийн аудитад санхүүгийн баримт материал тайланд аудитын шалгалт хийгдсэн.

Дотоод нөөц бололцоогоо ашиглан дараах засвар үйлчилгээг хийн гүйцэтгэсэн. Үүнд:

Байгууллагын хурлын заалны хана, таазыг хусаж цэвэрлэн, таазыг цагаан өнгөөр, ханыг цайвар цэнхэр өнгөөр эмульсдэж, дулааны шугам паарын цагаан өнгөөр будаж засварлаж, шинээр 20 ширхэг сандал худалдан авч тохижуулсан.



2.4. Мэдээллийн технологийн чиглэлээр

Тайлант хугацаанд газрын хэмжээнд мэдээллийн технологийн ажлын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, эрхэлсэн ажлын хүрээнд удирдлагыг мэдээллээр ханган, нийт 6 удаагийн дуудлага хүлээн авч албан хаагчдын компьютер, техник хэрэгсэлд шаардлагатай үйлчилгээг хийсэн.

Гурав. Бусад

Тус газар нь 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр шинэ жилийн баярын үйл ажиллагаагаа зохион байгуулан явуулсан. Төрийн үйл хэрэгт мэдлэг, ур чадвараа дайчлан идэвхи зүтгэл гаргаж, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж хамт олноо манлайлан ажилласан Байгууллагын “Хөдөлмөрийн аварга”-аар сантеникч М.Лутбаяр, Дорноговь аймаг дахь газрын “Хөдөлмөрийн аварга”-аар хяналтын улсын байцаагч Б.Сүлд-Очир, байгууллагын “Хүндэт өргөмжлөл”-өөр мэргэжилтэн Б.Энхчимэг, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр нярав Х.Цэвэлмаа, Аймгийн засаг даргын “Жуух бичиг”-ээр хяналтын улсын байцаагч О.Хэрлэн, “Өргөмжлөл”-өөр мэргэжилтэн Д.Баасансүрэн, Замын-Үүд сумын Засаг даргын “Өргөмжлөл”-өөр жижүүр Х.Эрдэнэбаатар, үйлчлэгч С.Энхтайван нар тус тус шагнуулсан болно.

2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлд албан хаагчдын судалгаа, байгууллагын батлагдсан бүтэц, хүний нөөцийн нэгдсэн системд нэвтэрч тайлан оруулсан албан хаагчаас гаргасан нууцын баталгааг гарган хүргүүлсэн.

Байгууллагын туг шинээр хийлгэж, газрын даргын өрөө, ханги боомт, Сайншанд төлөөлөл, Говьсүмбэр төлөөлөлийн өрөөнд байршуулсан.

2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж боомтын нөхцөл байдалтай танилцаж уулзалт хийсэн.

Газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/14 дугаар тушаалын дагуу Сайншанд дахь мэргэжилтэн П.Гантулгад ДГА бүртгэв, хасав 12 дугаар дардасыг мэргэжилтэн Т.Мягмардорж 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр хүлээлгэн өгч мөн “ISM” программ дээр ажиллах талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.

Газрын нийт 14 албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цаг хугацаанд үнэн зөв гаргуулан хүргүүлсэн.

Сайншанд дахь мэргэжилтэн П.Гантулга 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын нийт 40 албан хаагчдад Байгууллагын үндсэн чиг үүрэг, Дорноговь аймаг дахь газрын бүтэц, үйл ажиллагааны талаар товч танилцуулж, гадаадын иргэдийн паспорт, визийн ангилал, хугацааг хэрхэн уншиж мэдэх талаар ерөнхий ойлголт мэдээлэл өгч ажилласан.

2019 оны 01 сарын 19-ны өдөр мэргэжилтэн Т.Мягмардорж Хилийн 0108-р ангийн Авто замын боомтод үүрэг гүйцэтгэж буй нийт 16 албан хаагчдад Визийн шинэчилсэн журам, бүртгэл хасалтын талаар сургал зохион байгуулсан.

2019 оны 01 дүгээр сард ашиглалтанд орсон “Мандах наран” хороололын орон сууцанд жолооч Ч. Баярсайхан, үйчлэгч С.Энхтайван, Ч.Аюуш нарыг хамруулсан.

Мөн Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газраас 14 хоногт нэг удаа зохиогддог аймгийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд Говьсүмбэр аймаг дахь мэргэжилтэн Г.Төрболд оролсон.

Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтын зөвлөлийн хурал энэ оны 01 дүгээр сарын 18-ны өдөр болж хурлаар Замын-Үүд Олон Улсын хилийн боомтод 2018 онд хийсэн ажлын талаар байгууллагын дарга, удирдах албан тушаалтан нар товч мэдээлэл хийж, 2019 онд боомтод мөрдөх журамд оруулах саналаа солилцон баталсан.

2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Замын-Үүд сумын засаг даргын зөвлөлийн хурал болж хурлаар засаг даргын нөөцийн хөрөнгийн талаар хэлэлцсэн.

Сумын онцгой байдлын комисс гахайн мялзан өвчин, томуу, томуу төст өвчний тархалтын талаар хуралдаж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгааг танилцуулсан.

2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр БНХАУ-ын Эрээн хотын Цагдаагийн газраас зохион байгуулсан “Хаварын баяр” урлагийн тоглолтонд урилгаар Хяналтын улсын ахлах байцаагч Б.Баярхүү, хяналтын улсын байцаагч Б.Сүлд-Очир, сүлжээний инженер Д.Хоролсүрэн нар оролцсон.

2019 оны 01 дүгээр 25-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөгөөн болж уг зөвлөгөөнөөр 2019 оны төлөвлөгөөг баталсан.